



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 341

Улаанбаатар хот

“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн
өмчит үйлдвэрийн газрын 2018 оны
хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг
шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчит зарим хуулийн этгээдийг татан буулгах тухай” 09 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны “Татан буугдсан хуулийн этгээдийн эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай” 289 дүгээр тогтоолоор шилжиж ирсэн хөрөнгийг засварлах шаардлагыг харгалзан “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг шинэчлэн баталсантай холбогдуулан төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг захирал Р.Будад үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 316 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.


4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



0002317

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн
347 дугаар тогтоолын хавсралт

"Зам, тээврийн хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын
2018 оны их засвар, хөрөнгө оруулалтын шинэчилсэн төлөвлөгөө

Д/д	Хийгдэх ажил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (мянган төгрөг)	Нийт үнэ (мянган төгрөг)
Их засварын ажил					
1	"АЗТТТ" ТӨХК -ийн конторын барилгын засал, дээврийг иж бүрэн засварлаж, борооны ус зайлуулах хоолой угсрах	ком	1	70,059,900.00	70,059,900.00
2	Конторын барилгын дэргэд байрлах 30 автомашины гараашийн 360 м2 шалыг 20 см-ын зузаантай бетон шал цутгах, тэгшлэх, 1200 м2 дотор ханыг тэгшлэн засах, 3,6 м2 цонхнуудыг шилэн блокоор солих, 3,6 м2 цонхыг блокоор битүүлэх, 32 м3 блокоор 2 хаалгыг хааж, салбарын спорт сургалтын заал болгон тохижуулахад	ком	1	73,058,000.00	73,058,000.00
3	Төвийн одоогийн байрны өрөө тасалгааг нэгтгэн, өөрчлөн зохион байгуулж, Хурал, уулзалтын танхим шинээр бий болгох, урсгал засвар хийх, байрны гадна ханыг дулаалах, дээврийн засварт	ком	1	22,781,715.00	22,781,715.00
	Дүн				165,899,615.00
Барилгын тохижилт, нэмэлт тоноглол					
4	Дотоод сүлжээ тавиулах, шинэ байрыг холбоожуулахад	ком	1	2,100,000.00	2,100,000.00
5	Шинэ байрыг камержуулахад	ком	1	2,000,000.00	2,000,000.00
6	Шинэ байрны тохижилтонд зориулж хуйлдаг хөшиг суурилуулахад 2х2.5м	ш	15	110,000	1,650,000.00
7	Манаачийн байр шинээр барихад	ком	1	4,235,000.00	4,235,000.00
8	Спорт заал тохижуулахад	ком	1	6,765,000.00	6,765,000.00
9	Спорт заалны агааржуулалтанд	ком	1	3,339,500.00	3,339,500.00
10	Спорт заал, гараашийн барилгын сантехникийн усгралт, дулааны үзелийн засварын зардалд	ком	1	19,136,660.00	19,136,660.00
	Дүн				39,226,160.00
Техник хангамж, тавилга эд хогшил					
11	Хурлын ширээ 360х120х76 см	ш	2	3,325,000	6,650,000.00
12	Хурлын сандал	ш	30	195,000	5,850,000.00

13	Бичгийн ширээ	ш	2	550,000	1,100,000.00
14	Сандал	ш	2	228,200	456,400.00
16	Ханын шүүгээ	ш	2	712,000	1,424,000.00
17	Цэвэр усны аппарат	ш	2	200,000	400,000.00
18	Хурлын заал тохижуулах техник хэрэгсэл /проектор, дэлгэц/	ком	1	15,000,000.00	15,000,000.00
19	Гал тогооны техник хэрэгсэл	ком	1	3,486,000.00	3,486,000.00
	Дүн				34,366,400.00
	Нийт дүн				239,492,175.00